

# САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

## 2023/07

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Макро үзүүлэлт	Хэмжих нэгж	2023.VII	2022.VII	2023.VI	Өмнөх сараас	Өмнөх улирлаас	Оны эхнээс	Өнгөрсөн жилийн мөн үеэс
ДНБ 2023 оны 2-р улирал	их наяд ₮, оны үнээр	30.4	23.1	-	-	-	-	6.4% ▲
Инфляц	хувь	9.2	15.7	10.6	0.3% ▲	-	6.8% ▲	-6.5 нэгж хувиар ▼
Ажилгүйдлийн түвшин, 2023У2	хувь	5.8% 2023 оны У2	7.8% 2022 оны У2	-	-	-0.8% ▼ нэгж хувиар	-	-2.0% ▼ нэгж хувиар
Төсвийн тэнцэл	тэрбум ₮, өссөн дүнгээр	1360	-844.0	2025	-665 ▼	-	-	2204 ▲
Ам.долларын ханш	төгрөг	3442.35	3153.03	3438.26	-4.09 ▼	-	-	289.32 ▲
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар, өссөн дүнгээр	3674.7	1702.0	3290.8	384 ▲	-	-	1973 ▲
Нүүрсний экспорт	сая тонн, өссөн дүнгээр	35.4	11.1	29.5	5% ▲	-	-	3.2 дахин ▲
Зэсийн экспорт	мян.тонн, өссөн дүнгээр	891.3	856.2	764.3	-5% ▼	-	-	4% ▼
Төв банкны бодлогын хүү	хувь	13%	10%	13%	0%	-	0%	3% ▲
Гадаад валютын нөөц	тэрбум ам.доллар	3.83	2.87	3.81	0.25% ▲	-	-	33% ▲
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	хувь	8.77%	9.08%	8.66%	0.11 нэгж хувиар ▲	-	-	-0.31 нэгж хувиар ▼

### ОНЦЛОХ СТАТИСТИК:

2023 оны эхний хагаст ДНБ 6.4%-иар өсөв	ДНБ, 2023 оны эхний хагас жилд 6.4 хувиар өссөний -1.7 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар, 3.9 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар, 0.3 нэгж хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 3.5 нэгж хувийг үйлчилгээний салбар, 0.4 нэгж хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар бүрдүүлсэн байна.
Монгол Улсын гадаад валютын албан нөөц 33%-иар нэмэгдэв	Манай улсын гадаад валютын улсын нөөц 2023 оны долдугаар сард 3.8 тэрбум ам.доллар болжээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 32.9 хувиар нэмэгджээ.

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОНЦЛОХ ШИЙДВЭРҮҮД:


Шийдвэрүүд	Огноо	Зорилго, үр дүн
Улаанбаатар хотод газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байхыг даалгалаа.	2023/8/16	Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцэн баталлаа.

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### График


#### Нөлөөлөл

#### Инфляц




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 7 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 9.2 хувь, өмнөх оны эцсээс 6.8 хувиар өсөж, өмнөх сараас 0.3 хувиар буурсан байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 7 дугаар сард өмнөх сараас 0.3 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 0.4 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.1 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

#### Валютын ханш




Америк долларын ханш 2023 оны 7 дугаар сард 3442.35 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 289.32 төгрөгөөр, өмнөх сараас 4.09 төгрөгөөр суларсан байна. Гадаад валютын нийт албан нөөц өмнөх сараас 0.25%-иар, өнгөрсөн жилийн мөн үеэс 33%-иар тус тус өсөж, 3.83 тэрбум ам.долларт хүрээд байна.

#### Улсын төсөв



Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2023 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 12.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.5 (37.0%) их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 12.4 их наяд төгрөг болж, 3.7 (42.8%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2023 оны 7 дугаар сард 1.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 430.8 (29.9%) тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн орлого тусламжийн хэмжээ 1.9 их наяд төгрөг болж, 497.2 (36.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

#### Гадаад худалдаа



онгол Улс 2023 оны эхний 7 сард нийт 146 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 13.7 тэрбум америк доллар, үүнээс экспорт 8.7 тэрбум америк доллар, импорт 5.0 тэрбум америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.5 (22.2%) тэрбум америк доллароор, экспорт 2.2 (34.5%) тэрбум америк доллароор, импорт 261.1 (5.5%) сая америк доллароор тус тус өсжээ. Харин 2023 оны 7 дугаар сард экспорт өмнөх сараас 128.4 (10.1%) сая америк доллароор, импорт 60.7 (7.5%) сая америк доллароор тус тус буурсан байна.

#### Дэлхийн эдийн засагт

- Дэлхийн эдийн засгийн өсөлтийг 2022 онд 3.4 хувь байсан бол өсөлт 2023 онд 2.8 хувь болж буурч, 2024 онд 3.0 хувьд хүрэх төлөвтэй байна.

**Эх сурвалж: Олон улсын валютын сан**

- Инфляц бүс нутгийн хэмжээнд 2023 онд 4.2%, 2024 онд 3.3% буурах төлөвтэй байгаа N<sup>0</sup>

**Эх сурвалж: Азийн хөгжлийн банк, <https://ikon.mn/n/2tv5>**

Эх сурвалж:

1. [Статистикийн бюллетень, 7-р сар 2023 он, Үндэсний статистикийн хороо](#)

2. [Статистикийн бюллетень, 7-р сар 2023 он, Монголбанк](#)

3. [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)